
МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

НҮБ-ААС МОНГОЛ УЛСЫН БАРИЛГА, ОРОН СУУЦНЫ ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД

СУДАЛГАА



ЭДИЙН ЗАСГИЙН УХААНЫ МАГИСТР

МБҮА ТББ-ЫН СУДАЛГААНЫ МЕНЕЖЕР, "OPEN PARLIAMENT" ХӨТӨЛБӨРИЙН ЭКСПЕРТ

МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009



НҮБ-аас Монгол Улсын барилга, орон сууцны дэд бүтцийн чиглэлээр хэрэгжүүлсэн төслүүд

ЦУВРАЛ №10

Нэгдсэн Үндэстний Байгууллага

Ирээдүйгээ хамтдаа цогцлоох нь

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын 80 жилийн ойг хамтдаа тэмдэглэе!

УРИАЛГА

НҮБ 80 НАС ХҮРЛЭЭ

Хамтран ажиллагч эрхэм түншүүд болон НҮБ-ын дэмжлэг туслалцааг хүртсэн байгууллагуудад хандан "НҮБ-80" жилийн ойн үйл хэргийг дэмжиж буйгаа илэрхийлж, хамтран ажиллахыг урьж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын 80 жилийн ойг хамтдаа тэмдэглэе уриалгыг дэмжин энэхүү судалгааг хийлээ.

БАРИЛГЫН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ....4
1. ТАНИЛЦУУЛГА....5
2. НҮБ-ЫН ТУСЛАМЖИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД....6
2.1 НҮБ-ын Хабитат (UN-Habitat (UN Human Settlements Programme))....6
2.2 НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)....7
2.2 Бусад төслүүд....8
2.2.1 Мянганы Сорилын Сан (MCC)-гийн төслүүд....8
2.2.2 Дэд бүтцийн салбарыг үнэлэх хөтөлбөр (InfraSAP)- Харилцан хамааралтай, эдийн засгийг төрөлжүүлэх дэд бүтэц....9
3. ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ....10
3.1 Дүгнэлт....10
3.2 Бодлогын зөвлөмж....10
4. АШИГЛАСАН ЭХ ҮҮСВЭР....11

БАРИЛГЫН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024-II хагас	2025-II хагас
БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ			
Бүгд	их наяд.төг	3.9	5.1
Орон сууцны барилга	их наяд.төг	1.5	1.9
Орон сууцны бус барилга	их наяд.төг	1.3	1.6
Үйлдвэрийн	их наяд.төг	0.5	0.5
Худалдаа, үйлчилгээний	их наяд.төг	0.2	0.3
Эмнэлэг, сургууль, соёлын	их наяд.төг	0.4	0.6
Бусад	их наяд.төг	0.2	0.4
Инженерийн барилга, байгууламж	их наяд.төг	1.1	1.3
Эрчим хүчний	их наяд.төг	0.2	0.2
Холбооны	их наяд.төг	0.0	0.0
Төмөр зам	их наяд.төг	0.3	0.5
Авто зам	их наяд.төг	0.3	0.3
Гүүр, гүүрэн гарц	их наяд.төг	0.1	0.1
Далан, суваг, шугам, сүлжээ	их наяд.төг	0.3	0.2
Бусад (зам, талбайн бусад ажил)	их наяд.төг	0.1	0.1
Их засварын ажил	их наяд.төг	0.1	0.2
ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ			
	Хэмжих нэгж	**2024-08**	**2025-08**
Сэргээгдэх эрчим хүч	сая кВт.ц	50.9	62.5
Барилгын модон хаалга, цонх	м2	45.6	4.7
Вакуум цонх, хаалга	м2	6503	5780.4
Зүсмэл материал	м3	1212	630.3
Төмөр замын дэр мод	мян.м3	0.9	0.7
Цемент	мян.т	236.2	287.4
Шохой	мян.т	1.3	8.6
Төмөр бетон эдлэл	мян.м3	17.1	13.4
Бетон дэр	мян.ш	25.9	25.9

1. ТАНИЛЦУУЛГА

МБҮА ТББ-ын зүгээс НҮБ-ын 80 жилийн ойг хамтдаа тэмдэглэх уриалгыг дэмжин оролцож, энэхүү судалгаанд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын системийн байгууллагуудаас 2006 оноос өнөөг хүртэл Монгол Улсын барилга, дэд бүтцийн салбарт үзүүлсэн олон талт тусламжийг судалж, түүний нөлөөлөл, үр дүнг тодорхой харуулахыг зорьсон болно. Судалгаанд орон сууц, тээвэр, уур амьсгалд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлт, хотын засаглал, байгаль орчны тогтвортой байдлын чиглэлээр НҮБ-ын хөтөлбөрүүдийг хамруулахыг хичээлээ.

НҮБ нь Монгол Улстай 1961 оноос хойш 60 гаруй жилийн турш тасралтгүй хамтран ажиллаж, улсын тогтвортой хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) нь 1973 онд Улаанбаатар хотод төлөөлөгчийн газраа нээж тэгш, тогтвортой хөгжлийн төлөө ажилласаар ирсэн[1]. НҮБ-Хабитат (UN Habitat) нь 2006 оноос хойш Монгол Улсад дэмжлэг үзүүлж, 30 гаруй сум, дүүргийн 300,000 орчим хүнд үр өгөөжөө өгсөн 9 төсөл хэрэгжүүлж, 15 дунд хэмжээний нийгмийн байгууламж, 150 гаруй жижиг хүртээмжтэй дэд бүтцийн төслүүдийг барьж байгуулжээ[2]. НҮБ-ын санаачилгаар Монгол Улс худалдаа, бүс нутгийн эдийн засгийн интеграцийг сайжруулах зорилгоор 4286 км замыг хамарсан Азийн авто замын сүлжээнд 2004 онд нэгдсэн байна[3].

Монгол Улсын хотын хүн ам 67% болж өссөн бөгөөд үүнээс 47% нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч, нийслэлийн хүн амын 54.4% нь үндсэн үйлчилгээ хангалтгүй байгаа гэр хорооллын бүсэд амьдарч байна[4].

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (UNSDCF 2023-2027)-ний Стратегийн чиглэл 2: “Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт” гэж тодорхойлсон бөгөөд хот суурины хөгжлийн бодлогыг дэмжсэнээр эдийн засгийг төрөлжүүлэх, ногоон технологи нэвтрүүлэх, орон нутгийн эдийн засгийг тэнцвэртэй хөгжүүлэх, залуучууд болон эмэгтэйчүүдэд зориулсан ажлын байр бий болгох үр дүн гарна гэж тодорхойлсон байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орчинг бий болгосноор орон нутгийн захиргааны түвшинд уур амьсгалын өөрчлөлтийг харгалзан төлөвлөлт хийх, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, гамшгийн эрсдэлийг бууруулах үр дүн гарах бол засаглал, хүний эрхийг дэмжсэнээр нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, орон нутгийн түвшинд үйлчилгээ сайжруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үр дүн гарна гэжээ.

[1] Mongolia | United Nations Development Programme

[2] Urbanization in Mongolia: Building inclusive & sustainable cities (Монгол дахь хотжилт: Хүртээмжтэй, тогтвортой хотуудыг бий болгох)

[3] Infrastructure – Mongolia Inc

[4] Монгол дахь хотжилт: Хүртээмжтэй, тогтвортой хотуудыг бий болгох

2. НҮБ-ЫН ТУСЛАМЖИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

2.1 НҮБ-ын Хабитат (UN-Habitat (UN Human Settlements Programme))

Хот байгуулалт, орон сууцны дэд бүтэц түүний дотор хүн төвтэй хот байгуулалтын бодлогыг дэмжиж ажилладаг гэж дүгнэж болно. НҮБ-ын Хабитат байгууллага болон ДЭМБ хамтран хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгах, нийгмийн эрх тэгш байдлыг хангах, олон улсын стандартууд болон НҮБ-ын зөвлөмжийг дагаж мөрдөхөд анхаарч, Монгол Улсад хүн төвтэй, эрүүл, аюулгүй хот байгуулалтын бодлогыг болон тогтвортой хотын хөгжлийг дэмжих чиглэлээр хамтран ажиллаж байна.

Тус байгууллага нь 2006 оноос өнөөг хүртэл иргэдийн оролцоонд тулгуурласан хөгжлийн аргачлалыг нэвтрүүлсэн 9 төсөл хэрэгжүүлж, Улаанбаатар хотын гэр хорооллын 30 гаруй нэгж хэсэгт нийт 300,000 орчим хүнийг хамруулжээ. 2008–2013 онд нийт 69,265 ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд гол санхүүжүүлэгч нь Азийн Хөгжлийн Банк (АХБ) байв. Төслийн хүрээнд олон нийтийн төв, нийтийн халуун ус, сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг гэх зэрэг дунд оврын 15 нийгмийн байгууламж, дэд бүтцийн 150 гаруй жижиг төсөл хэрэгжүүлсэн байна. Эдгээр төслүүдээс 2 төслийг жишээ болгон орууллаа. Үүнд:

Хүснэгт 1. НҮБ-ын Хабитат байгууллагаас хэрэгжүүлсэн гол төслүүд, 2006-2013

Төслийн нэр	Хэрэгжсэн он	Санхүүжүүлэгч	Төслийн товч танилцуулга
Нийслэл хотын гэр хорооллыг шинэчлэх стратеги, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (GUSIP)	2006-2010	Хотуудын холбоо (Cities Alliance)	• Ядуурлаас гарахад чиглэсэн хотын гэр хорооллыг сайжруулах анхны стратегийг боловсруулахад Улаанбаатар хотын захиргаанд тусалсан. • 2007 оны 7 дугаар сард НИТХ-аас баталсан. • Гэр хорооллыг төв, дунд, хот орчмын гэсэн гурван бүсэд ангилсан
Олон нийтийн оролцоонд тулгуурласан гэр хорооллын сайжруулалтын төсөл	2009–2013	Японы Засгийн газар	Гэр хорооллын 50,000 орчим оршин суугчдын амьдралын чанарыг сайжруулах зорилготой. 5 хороонд, 47 хэсэгт Иргэдийн хөгжлийн хороо, 191 анхан шатны бүлэг ажилласан • Иргэдийн хөгжлийн хорооны 792 гишүүн түр ажлын байраар хангагдсан • 81 иргэн байнгын ажлын байранд ажилд орсон • 17 иргэн барилгын туслах ажилчин (түр)-аар ажилд орсон

2.2 НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) нь 1973 онд Улаанбаатар хотод Төлөөлөгчийн газраа байгуулсан цагаас өнөөг хүртэл манай улсын нийгэм, эдийн бүхий л салбарт дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж ирсэн юм. Тус байгууллагаас уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй дэд бүтцийг хөгжүүлэхийг дэмжих, байгаль орчин, экосистемийг хамгаалах тогтвортой үйл ажиллагааг дэмжих, сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх, цахим засаглал, инновацийн дэмжлэг, бодлогын зөвлөгөө өгөх үйлчилгээ, чадавх бүрдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Эрчим хүчний чиглэлээр эрчим хүчний хүртээмж ба найдвартай байдлыг нэмэгдүүлэх, нүүрснээс хамааралтай дэд бүтцээс шат дараатай шилжилт хийхийг дэмжих ENSURE төсөл (Дэлхийн байгаль орчны сангийн санхүүжилттэй), малчдыг чадавхжуулах замаар цаг уурын хүндрэлийг даван туулах дархлааг бэхжүүлэх, барилгын салбарын эрчим хүч хэмнэлтийн төсөл - барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй барилгын арга барил болон шинэлэг системийг дэмжих хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны хөгжлийг дэмжиж арилжааны банкууд олон улсын байгууллагуудтай хамтран эрчим хүчний хэмнэлттэй байшингийн зээлийн туршилтын хөтөлбөр хэрэгжүүлж, 2021 оны эцэс гэхэд эрчим хүчний хэмнэлттэй 26 байшин баригдсан, мөн гэр хорооллын захын бүсийн албан бус суурьшлын оршин суугчдын амьдралын чанарыг сайжруулахад чиглэгдсэн байв.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP), Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ) (хуучин нэрээр) хамтран барилгын салбарт эрчим хүчний хэмнэлтийн техник технологийн нэвтрүүлэлтийг өргөжүүлж, зах зээлийн өөрчлөлтийг дэмжих зорилгоор "Үндэсний хэмжээнд тохирсон нөлөөллийг бууруулах арга хэмжээ" төсөл (NAMA-Nationally Appropriate Mitigation Actions)-ийг Дэлхийн байгаль орчны сан (Global Environmental Facility - GEF)-гийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн байна. Барилгын салбар нь Монгол Улсын хүлэмжийн хийн нийт ялгарлын 65%-ийг эзэлдэг. Энэхүү төслийн гол бүрэлдэхүүн хэсгүүд нь:

1. Барилгын салбарын эрчим хүчний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлыг үнэлэх, суурь түвшин тогтоох:
2. Үндэсний хэмжээний нөлөөллийг сааруулах арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх
3. Үндэсний хэмжээнд тохирсон нөлөөллийг бууруулах арга хэмжээний үр дүнг хянах тогтолцоо, хэмжих, тайлагнах, баталгаажуулах систем (MRV) бий болгох байв.

Төслийн үр дүнд хүлэмжийн хийн ялгарал 64,219 tCO2e (нүүрсхүчлийн хийн тонн эквивалент) болж буурсан, эрчим хүчний зохицуулах хорооны шинэ оффисын барилгад нарны зай суурилуулж, цахилгааны хангамжийн 60%-ийг нарны эрчим хүчнээс авдаг болсон, сургууль, төрийн байгууллагуудын барилгад эрчим хүч хэмнэх технологи нэвтрүүлсэн байна. Түүнчлэн хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн цахим систем бий болгосон нь Монгол Улс 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 14%-иас 22.7% хүртэл бууруулах зорилтын хэрэгжилтэд хувь нэмэр оруулжээ.

НҮБХХ-ийн “Нарны эрчим хүчээр Улаанбаатарын гэр хорооллыг шинэчлэх нь” төсөл Чингэлтэй дүүрэгт 2025 оны 09 дүгээр сараас хэрэгжиж эхэлж байгаа бөгөөд энэхүү төслийг БНХАУ-ын Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг санхүүжүүлж байгаа юм.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP), Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO), НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага (UNIDO) хамтран “Ногоон барилгын хөтөлбөр” хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү төсөл нь барилгын салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах, ногоон барилгын шалгууруар сургууль, цэцэрлэг зэрэг нийтийн барилгыг барих чадавхыг сайжруулах, Сонгинохайрхан дүүргийн 122 дугаар сургуулийн өргөтгөлийн "Сургуулийн ногоон барилга" зураг төсөл боловсруулахад чиглэж байжээ. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр барилгын салбарын тогтвортой хөгжлийг дэмжсэн, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй барилга барих дадлыг бий болгож, орон нутгийн чадавхыг бэхжүүлэхэд чухал дэмжлэг болсон байна.

2.2 Бусад төслүүд

2.2.1 Мянганы Сорилын Сан (МСС)-гийн төслүүд

АНУ-ын Мянганы сорилтын корпорац нь эдийн засгийн өсөлтөөр ядуурлыг бууруулах зорилгын хүрээнд тодорхой шалгуурт тэнцсэн бага, дунд орлоготой улс орнуудтай Компакт гэрээ байгуулан, 5 жилийн хугацаатай тэтгэлэг, буцалтгүй тусламж олгодог.

Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпорац (МСК)-ын хооронд 2007 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан Мянганы сорилтын анхны Компакт гэрээ 2008-2013 онд хэрэгжиж, хөрөнгийн эрх, эрүүл мэнд, мэргэжлийн боловсрол, эрчим хүч, байгаль орчин, зам тээврийн салбарт нийт 284.9 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн билээ.

Талууд хамтран 2016-2018 онуудад нарийвчилсан судалгаа хийсний дүнд газрын доорх усны шинэ эх үүсвэр байгуулах, хаягдал усыг дахин боловсруулж, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, усны салбарын урт хугацааны тогтвортой байдлыг хангах гэсэн чиглэлээр хөрөнгө оруулахаар тогтсон. Энэ шийдвэрт үндэслэн МСК-ын Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хурлаар Монгол Улстай хоёр дахь Компакт гэрээ байгуулах асуудлыг хэлэлцэн дэмжиж, гэрээнд гарын үсэг зурах мэдэгдлийг Конгресст хүргүүлсэн байна. Ийнхүү Монгол Улсын Засгийн газар болон МСК нь эдийн засгийн өсөлтийг дэмжих замаар ядуурлыг бууруулах зорилгын хүрээнд АНУ-ын Засгийн газрын 350 сая ам.долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 111.76 сая хүртэл ам.долларын хөрөнгө оруулалтаар хэрэгжих Мянганы сорилтын хоёр дахь Компакт гэрээнд 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр гарын үсэг зурж, Монгол Улсын Их Хурал Компакт гэрээг 2019 оны нэгдүгээр сарын 31-ний өдөр соёрхон баталсан юм.

Энэхүү Компакт гэрээний хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөрийн хүрээнд

харилцан уялдаа бүхий дараах гурван томоохон төсөл, үйл ажиллагаанд хөрөнгө оруулна.

Үүнд:

1. Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа буюу Улаанбаатар хотын баруун доод хэсэг Биокомбинат, Шувуун фабрик орчимд газрын доорх усны шинэ эх үүсвэрүүдийг холбогдох дэд бүтэц, усан сан болон ус цэвэршүүлэх дэвшилтэт технологи бүхий үйлдвэрийн хамт байгуулах төсөл.
2. Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагаа буюу шинэ Төв цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал усыг дахин боловсруулж, гурав болон дөрөвдүгээр ДЦС-д нийлүүлэх үйлдвэрийг холбогдох дэд бүтцийн хамт байгуулах төсөл.
3. Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа буюу Улаанбаатар хотын ус хангамжийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн бодлого, хууль эрх зүйн орчин, институцийн чадавхыг сайжруулах төсөл.

Улаанбаатар хотын усны тогтвортой хангамжийг хангахад чиглэсэн томоохон дэд бүтцийн төсөл нь 93 сая долларын санхүүжилтээр усны хомсдолын хүндрэлийг шийдэж, хувийн хэвшлээр удирдуулсан эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой. Энэ төсөл нь Улаанбаатарын адгийн усны шинэчлэлийн станц (AWPP)

- Улаанбаатараас доош урсгал дахь шинэ гүний усны худаг
- Аж үйлдвэрийн зориулалтаар өндөр чанарын цэвэршүүлсэн ус нийлүүлэх шинэ бохир усыг дахин боловсруулах станц болон дамжуулах хоолой
- Институцийн чадавхийг нэмэгдүүлэх болон Улаанбаатар хотын усны хангамжийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах шинэчлэл гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй.

Нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр амжилттай хэрэгжсэнээр Улаанбаатар хотын урт хугацааны ус хангамжийг ойролцоогоор 64 сая шоо метр буюу өнөөгийн түвшнээс 80 хувиар нэмэгдүүлж, нийслэл Улаанбаатар хотын хүн амын ундны болон ахуйн хэрэглээний усны хурдтай өсөн нэмэгдэж буй хэрэгцээг урт хугацаанд, тогтвортой хангах, эдийн засгийн ирээдүйн өсөлтийг дэмжих таатай нөхцөлийг бий болгох юм.

2.2.2 Дэд бүтцийн салбарыг үнэлэх хөтөлбөр (InfraSAP)- Харилцан хамааралтай, эдийн засгийг төрөлжүүлэх дэд бүтэц

Монгол Улсын эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлж, өрсөлдөх чадварыг нь сайжруулахад шаардлагатай байгаа дотоодын дэд бүтцийг хөгжүүлэхэд шаардлагатай нотолгоон дээр суурилсан судалгаа, шийдвэр гаргах суурь хүрээг боловсруулах нь энэхүү Дэд бүтцийн салбарыг үнэлэх хөтөлбөрийн гол зорилго юм.

Дэлхийн банкны “Дэд бүтцийн салбарыг үнэлэх хөтөлбөр”-үүд нь бүх боломжит төрлийн санхүүжилт, мэргэжлийн боловсон хүчин, шийдэл гээд бүх эх үүсвэрийг хөшүүрэглэж, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад шаардлагатай байгаа дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн судалгаа шинжилгээг боловсруулдаг.

3. ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

3.1 Дүгнэлт

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-аас Монголын барилгын салбарт үзүүлсэн тусламж нь манай улсын тогтвортой хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байна.

НҮБ нь манай улсын барилгын салбарыг хөгжүүлэх, тогтвортой болгох чиглэлээр олон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн бөгөөд эдгээр нь ялангуяа эрчим хүчний хэмнэлт, ногоон барилга, орон сууцны асуудал, хотын хөгжлийн чиглэлд төвлөрч ажилласан нь Монгол Улс дундаас дээш орлоготой орон болж хөгжих замналд үнэлж баршгүй дэмжлэг үзүүлж ирсэн юм. Цаашид ч энэхүү хамтын ажиллагаа улам бэхжиж, тогтвортай, хүртээмжтэй хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулна.

Монгол Улс НҮБ-ын тусламжтайгаар дэд бүтцийн салбарт томоохон ахиц дэвшилтэт хүрч байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) болон бусад донор байгууллагууд хамтран манай улсын барилга, дэд бүтцийн салбарт үзүүлсэн дэмжлэг, хэрэгжүүлсэн төслүүдийн гол үр дүнг нэгтгэн дүгнэвэл:

- ✓ Эрчим хүчний хэмнэлт - барилгын салбарт эрчим хүч хэмнэх технологи өргөн нэвтэрч, хүлэмжийн хийн ялгарлыг мэдэгдэхүйц бууруулсан
- ✓ Ногоон барилга - тогтвортой, байгаль орчинд ээлтэй барилга барих чадавх, ойлголт нэмэгдсэн
- ✓ Хотын хөгжил - гэр хорооллын шинэчлэл, орон сууцны асуудлыг шийдвэрлэх замаар хотын хөгжлийг дэмжсэн
- ✓ Чадавх бэхжүүлэлт - үндэсний хэмжээнд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чадавхыг сайжруулсан
- ✓ Олон улсын стандарт - олон улсын шилдэг туршлага, стандартыг Монголд нэвтрүүлэх.

3.2 Бодлогын зөвлөмж

МУ-ын Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Монгол Улсад НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 2023-2027 онд хэрэгжүүлэх Хөгжлийн туслалцааны хөтөлбөрийн баримт бичиг, мөн НҮБ-аас Монгол Улсад хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ” баримт бичгүүдийн хүрээнд цаашид НҮБ, бусад донор байгууллагуудтай дараах чиглэлээр хамтран ажиллах боломжтой юм. Үүнд:

1. Барилга, зам тээврийн салбарын уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, улмаар даван туулах арга хэмжээнд хяналт шинжилгээ хийх, тайлагнах, баталгаажуулах;
2. Хүн амын амьдрах таатай нөхцлийг жигд бүрдүүлэх, гэр хорооллыг шинэчлэх, орон сууцжуулахад хамтран ажиллах;
3. Ногоон бизнес эрхлэх чадавхийг бий болгох, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх
4. Залуучууд болон эмэгтэйчүүдэд зориулсан ажлын байр бий болгох төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх

5. Хүний нөөцийг чадавхжуулах, мэргэжлийн ажилтан бэлтгэх хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх;
6. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, төр, хувийн хэвшил, орон нутгийн түншлэлийг бий болгох;
7. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орчинг бий болгох, ногоон барилга, хот төлөвлөлт, хот байгуулалтыг сайжруулах;
8. Үйлдвэрлэлийн арга ажиллагааг байгаль орчинд илүү ээлтэй болгох;
9. ТХЗ-ын “хөгжлийн гадна хэнийг ч үлдээхгүй” гэсэн зарчмын дагуу хүн амын бүлэг бүрт чиглэсэн болон өрхийн орлогод нийцсэн орон сууцжуулалтын бодлогыг хэрэгжүүлэх.

4. АШИГЛАСАН ЭХ ҮҮСВЭР

1. Монгол Улс дахь НҮБ-ын 2024 оны онцлох үйл явдлын тойм - mongolia.un.org
2. MCC Mongolia Water Compact - www.mcc.gov
3. UNESCAP Infrastructure Financing материал
4. Mongolia MINIS Project - worldbank.org
5. НҮБ-ын цахим засаглалын хөгжлийн индекс 2024
6. Монгол Улсад НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс 2023-2027 онд хэрэгжүүлэх хөгжлийн туслалцааны хөтөлбөрийн баримт бичиг
7. ДБ: Монгол Улстай хэрэгжүүлэх түншлэлийн стратеги (World Bank Mongolia InfraSAP document)
8. www.1212.mn